

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлагналын аудит
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани
ХНХЯ	Хөдөлмөр, нийгэм хамгааллын яам
ЧСС	Чадамжид суурилсан сургалт
ТМБС	Техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалт
ГОУХАН	Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах
БНД	Багануур дүүрэг
ПТК	Политехникийн коллеж
МСҮТ	Мэргэжил сургалтын үйлдвэрлэлийн төв

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	14
3. Аудитын тайлан.....	15
3.1. Ерөнхий зүйл.....	15
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	15
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	16
3.4. Материаллаг байдал	16
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	16
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	17
3.7. Шилэн дансны мэдээлэл	18
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
3.9. Аудитын илрүүлэлт.....	19
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	20
4. Менежментийн захидал	21
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	23



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

“МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ,
СУРГАЛТЫН ҮНЭЛГЭЭ, МЭДЭЭЛЭЛ,
АРГА ЗҮЙН ТӨВ”-ИЙН ДАРГА
Ц.БАТДОРЖ ТАНАА

2021.02.25 № 08/532
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвийн 2020 оны оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Мэргэжлийн боловсрол, сургалтын үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлж дэмжигдсэн “Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвийн үйл ажиллагааны болон зардлын хэмнэлтийг тооцох, зарцуулах, тайлагнах журам”-ыг холбогдох байгууллагуудаар батлуулж мөрдвөл төсөвт орох үндсэн үйл ажиллагааны орлогын хэмжээг нэмэгдүүлэх боломж байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайланд бидний илрүүлэлтээр дараах алдаа зөрчлүүд материаллаг боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

- Худалдан авах ажиллагаа хуулийн дагуу зохион байгуулаагүй 38,050.0 мянган төгрөгийн бараа ажил үйлчилгээ шууд аргаар худалдаж авсан;
- Цахим баримтын системд 12,656.7 мянган төгрөгийн и-баримт бүртгэгдээгүй;
- Үндсэн хөрөнгө дансанд 238,012.6 мянган төгрөгийн үлдэх өртөггүй хөрөнгө бүртгэлтэй;
- Бараа материалын тайлангаар дамжуулалгүй 6,969.3 мянган төгрөгийн материалыг зардалд шууд бүртгэсэн;
- Нийгмийн даатгалын шимтгэл болон татварын өрийг 4,130.6 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн;
- Дотоод хяналтын тогтолцоо хангалтгүй

зөрчлүүд нь ТБОНӨХБАҮХАТХ, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын ерөнхий хууль зэрэг эрх зүйн акт, УСНББОУС-1, УСНББОУС-17 стандарттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв, үнэлгээ ба хэмжилт, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль. Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	59,434,568.45	435,610,415.15
33	АВЛАГА	34,803,304.76	47,241,517.03
33300	Татаас, санхүүжилтийн авлага	34,803,304.76	47,012,895.43
335	Бусад авлага	-	228,621.60
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	228,621.60
34	УРЬДЧИЛГАА	508,561.00	328,299,600.00
34600	Урьдчилж гарсан зардал	203,776.00	328,299,600.00
3471	Урьдчилгаа тооцоо	304,785.00	-
34713	Цалингийн урьдчилгаа	304,785.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	24,122,702.69	60,069,298.12
354	Хангамжийн материал	24,122,702.69	60,069,298.12
35410	Бичиг хэргийн материал	16,447,261.00	6,228,392.00
35420	Аж ахуйн материал	621,690.00	746,360.00
35430	Сэлбэг хэрэгсэл	341,000.00	665,380.00
35450	Барилгын засварын материал	160,000.00	-
35470	Бусад хангамжийн материал	6,552,751.69	52,429,166.12
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,589,987,810.42	1,972,492,944.68
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,589,987,810.42	1,972,492,944.68
392	Биет хөрөнгө	1,589,883,920.98	1,969,523,944.68
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,413,098,075.21	1,413,098,075.21
39202	Хуримтлагдсан элэгдэл	(124,517,612.14)	(162,936,753.10)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	74,096,480.00	74,096,480.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(36,715,143.75)	(47,991,418.27)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	185,943,700.82	921,488,413.93
39206	Хуримтлагдсан элэгдэл	(16,970,293.72)	(449,224,192.52)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	98,782,769.66	239,636,642.46
39208	Хуримтлагдсан элэгдэл	(3,834,055.10)	(18,643,303.03)
393	Биет бус хөрөнгө	103,889.44	2,969,000.00
39301	Програм хангамж	880,000.00	3,887,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(776,110.56)	(918,500.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,649,422,378.87	2,408,103,359.83
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	10,384,528.58	18,101,482.22
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	10,384,528.58	18,101,482.22
413	Өглөг	10,384,528.58	18,101,482.22
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	126,578.58	9,670,223.62
4136	Бусад өглөг	10,257,950.00	8,431,258.60
41361	Байгууллагад төлөх өглөг	10,257,950.00	5,250,006.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	3,181,252.60
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,639,037,850.29	2,390,001,877.61
51	Засгийн газрын хувь оролцоо	1,639,037,850.29	2,390,001,877.61

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	8,944,100.00	8,944,100.00
51101	Өмч: - төрийн	8,944,100.00	8,944,100.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,630,093,750.29	2,381,057,777.61
51210	Өмнөх үеийн үр дүн	1,421,748,723.23	1,630,093,750.29
51220	Тайлант үеийн үр дүн	208,345,027.06	750,964,027.32
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,649,422,378.87</u>	<u>2,408,103,359.83</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	823,257,766.00	2,219,531,907.09
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	400,599,776.00	919,793,080.79
120	Нийтлэг татварын бус орлого	400,599,776.00	919,793,080.79
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	400,599,776.00	919,793,080.79
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	115,969,630.00	128,607,519.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	284,630,146.00	791,185,561.79
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	422,657,990.00	1,299,738,826.30
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	125,136,600.00	743,132,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	125,136,600.00	743,132,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	297,521,390.00	553,753,496.30
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	225,521,390.00	391,489,861.30
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	72,000,000.00	141,463,635.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	20,800,000.00
1330	Төсвийн захирагчдаас	-	2,852,530.00
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	2,852,530.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	614,912,738.94	1,468,567,879.77
21	УРСГАЛ ЗАРДАЛ	614,912,738.94	1,468,567,879.77
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	612,863,369.20	1,405,845,486.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	177,142,167.70	697,982,254.88
210101	Үндсэн цалин	123,290,396.00	617,362,965.88
210102	Нэмэгдэл	53,851,771.70	39,218,289.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	41,401,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,205,259.91	89,650,406.27
210201	Тэтгэврийн даатгал	14,976,102.14	62,379,756.07
210202	Тэтгэмжийн даатгал	2,338,268.28	7,113,762.55
210203	ҮОМШӨ-ний даатгал	841,555.65	5,375,170.04
210204	Ажилгүйдлийн даатгал	841,555.65	1,343,792.51
210205	Эрүүл мэндийн даатгал	4,207,778.19	13,437,925.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,428,398.82	15,722,756.97
210301	Гэрэл, цахилгаан	2,449,500.00	2,497,104.24
210302	Түлш, халаалт	3,238,400.00	10,898,318.42
210303	Цэвэр, бохир ус	740,498.82	2,327,334.31
2104	Хангамж, бараа материалын зардал	40,903,799.31	76,430,265.69
210401	Бичиг хэрэг	29,165,890.00	26,273,282.78
210402	Тээвэр, шатахуун	5,940,000.00	5,737,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,372,050.22	3,966,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	168,700.00	37,199,198.91

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,257,159.09	3,254,484.00
2105	Нормативт зардал	61,068,150.00	8,985,600.00
210502	Хоол, хүнс	61,068,150.00	8,985,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	1,120,320.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	1,120,320.00
2107	Томилолт, зочны зардал	20,994,600.00	16,819,420.00
210702	Дотоод албан томилолт	20,994,600.00	16,819,420.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,998,750.00	3,412,656.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	22,383,350.00	1,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	138,996.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	60,404.00	145,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,416,000.00	2,267,156.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	251,122,243.46	495,721,806.87
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	76,203,160.00	1,850,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	117,549,226.00	352,470,545.46
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	57,369,857.46	141,400,561.41
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,049,369.74	62,722,393.09
2132	Бусад урсгал шилжүүлэг	400,000.00	57,044,400.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	400,000.00	
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	57,044,400.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,649,369.74	5,677,993.09
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,649,369.74	5,677,993.09
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>208,345,027.06</u>	<u>750,964,027.32</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	594,854,020.00	1,463,740,782.30
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	115,969,630.00	129,516,601.00
120	Нийтлэг татварын бус орлого	115,969,630.00	129,516,601.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	115,969,630.00	129,516,601.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	115,969,630.00	129,516,601.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	478,884,390.00	1,334,224,181.30
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	125,136,600.00	743,132,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	125,136,600.00	743,132,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	353,747,790.00	591,091,381.30
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	281,747,790.00	394,024,441.54
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	72,000,000.00	176,266,939.76
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	20,800,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	574,854,020.00	1,462,585,782.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	574,854,020.00	1,462,585,782.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	538,001,345.50	1,352,850,493.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	177,011,368.58	696,645,072.16
210101	Үндсэн цалин	129,091,804.99	462,366,299.82
210102	Нэмэгдэл	45,572,905.59	157,967,552.19
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,346,658.00	57,544,389.20
210104	Урамшуулал	-	18,766,830.95
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,418,557.88	87,278,044.19
210201	Тэтгэврийн даатгал	15,414,139.59	53,802,920.61
210202	Тэтгэмжийн даатгал	2,349,593.58	9,867,069.18
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,021,373.97	4,679,825.95
210204	Ажилгүйдлийн даатгал	693,641.63	2,980,020.04
210205	Эрүүл мэндийн даатгал	3,939,809.11	15,948,208.41
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,428,398.82	15,722,756.97
210301	Гэрэл, цахилгаан	2,449,500.00	2,497,104.24
210302	Түлш, халаалт	3,238,400.00	10,898,318.42
210303	Цэвэр, бохир ус	740,498.82	2,327,334.31
2104	Хангамж, бараа материалын зардал	19,693,793.22	64,332,055.00
210401	Бичиг хэрэг	8,549,443.00	15,838,455.00
210402	Тээвэр, шатахуун	5,940,000.00	5,737,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,257,050.22	3,966,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	222,700.00	36,913,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,724,600.00	1,877,200.00

2105	Нормативт зардал	60,797,550.00	8,985,600.00
210502	Хоол, хүнс	60,797,550.00	8,985,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,260,200.00	1,467,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,001,200.00	1,467,700.00
210604	Урсгал засвар	259,000.00	
2107	Томилолт, зочны зардал	20,947,250.00	16,819,420.00
210702	Дотоод албан томилолт	20,947,250.00	16,819,420.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	34,436,750.00	7,708,880.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	22,383,350.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		1,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	138,996.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	60,404.00	145,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,416,000.00	2,063,380.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	6,438,000.00	4,500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	194,007,477.00	453,890,965.46
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	76,128,560.00	1,850,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	117,878,917.00	452,040,265.46
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,852,674.50	109,735,288.52
2132	Бусад урсгал шилжүүлэг	400,000.00	57,044,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	400,000.00	57,044,400.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	36,452,674.50	52,690,888.52
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,649,369.74	4,461,045.09
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	34,803,304.76	48,229,843.43
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>20,000,000.00</u>	<u>1,155,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	20,000,000.00	1,155,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	20,000,000.00	1,155,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	20,000,000.00	1,155,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	20,000,000.00	1,155,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(20,000,000.00)</u>	<u>(1,155,000.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/				
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 1-нээрх үлдэгдэл	8,944,100.00	1,421,748,723.23	1,430,692,823.23
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,944,100.00	1,421,748,723.23	1,430,692,823.23
C07	Тайлант үеийн үр дүн		208,345,027.06	208,345,027.06
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,944,100.00	1,630,093,750.29	1,639,037,850.29
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,944,100.00	1,630,093,750.29	1,639,037,850.29
D08	Тайлант үеийн үр дүн	-	750,964,027.32	750,964,027.32
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,944,100.00	2,381,057,777.61	2,390,001,877.61

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	938,594,800.00	868,188,355.91	70,406,444.09	92.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	938,594,800.00	868,188,355.91	70,406,444.09	92.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	881,547,400.00	811,143,955.91	70,403,444.09	92.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	699,490,100.00	669,790,974.16	29,699,125.84	95.75
210101	Үндсэн цалин	458,131,400.00	450,012,249.82	8,119,150.18	98.23
210102	Нэмэгдэл	165,005,700.00	143,467,504.19	21,538,195.81	86.95
210103	Унаа хоолны хөнгөлөлт	62,040,000.00	57,544,389.20	4,495,610.80	92.75
210104	Урамшуулал	14,313,000.00	18,766,830.95	(4,453,830.95)	131.12
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	92,034,100.00	83,928,869.78	8,105,230.22	91.19
210201	Тэтгэврийн даатгал	64,764,500.00	50,453,746.20	14,310,753.80	77.90
210202	Тэтгэмжийн даатгал	6,817,300.00	9,867,069.18	(3,049,769.18)	144.74
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,453,900.00	4,679,825.95	774,074.05	85.81
210204	Ажилгүйдлийн даатгал	1,363,500.00	2,980,020.04	(1,616,520.04)	218.56
210205	Эрүүл мэндийн даатгал	13,634,900.00	15,948,208.41	(2,313,308.41)	116.97
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,481,100.00	15,722,756.97	10,758,343.03	59.37
210301	Гэрэл, цахилгаан	5,086,400.00	2,497,104.24	2,589,295.76	49.09
210302	Түлш, халаалт	17,118,900.00	10,898,318.42	6,220,581.58	63.66
210303	Цэвэр, бохир ус	4,275,800.00	2,327,334.31	1,948,465.69	54.43
2104	Хангамж, бараа материалын зардал	29,838,500.00	26,416,055.00	3,422,445.00	88.53
210401	Бичиг хэрэг	15,574,100.00	13,122,455.00	2,451,645.00	84.26
210402	Тээвэр, шатахуун	6,044,300.00	5,737,300.00	307,000.00	94.92
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,921,600.00	3,766,000.00	155,600.00	96.03
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,308,400.00	1,913,100.00	395,300.00	82.88
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,990,100.00	1,877,200.00	112,900.00	94.33
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,467,700.00	1,467,700.00	-	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,467,700.00	1,467,700.00	-	100.00
2107	Томилолт, зочны зардал	7,966,400.00	2,621,020.00	5,345,380.00	32.90
210702	Дотоод албан томилолт	7,966,400.00	2,621,020.00	5,345,380.00	32.90
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,131,900.00	8,863,880.00	12,268,020.00	41.95

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	1,000,000.00	1,000,000.00	50.00
210803	Даатгалын үйлчилгээ	158,000.00	-	158,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	242,600.00	145,500.00	97,100.00	59.98
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,503,800.00	3,218,380.00	1,285,420.00	71.46
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	14,227,500.00	4,500,000.00	9,727,500.00	31.63
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,137,600.00	2,332,700.00	804,900.00	74.35
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,440,700.00	1,850,700.00	590,000.00	75.83
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	696,900.00	482,000.00	214,900.00	69.16
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	57,047,400.00	57,044,400.00	3,000.00	99.99
2132	Бусад урсгал шилжүүлэг	57,047,400.00	57,044,400.00	3,000.00	99.99
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	57,047,400.00	57,044,400.00	3,000.00	99.99
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	938,594,800.00	868,188,355.91	70,406,444.09	92.50
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	743,132,800.00	739,454,806.91	3,677,993.09	99.51
131001	Улсын төсвөөс санхүүжих	743,132,800.00	739,454,806.91	3,677,993.09	99.51
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	195,462,000.00	128,733,549.00	66,728,451.00	65.86
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	195,462,000.00	128,733,549.00	66,728,451.00	65.86
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	45.00	50.00	(5.00)	
620001	Удирдах ажилтан	1.00	2.00	(1.00)	
620002	Гүйцэтгэх ажилтан	43.00	45.00	(2.00)	
620003	Үйлчлэх ажилтан	1.00	3.00	(2.00)	

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	353,747,790.00	591,091,381.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	353,747,790.00	591,091,381.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	318,944,485.24	542,861,537.87
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,679,684.74	26,854,098.00
210101	Үндсэн цалин	-	12,354,050.00
210102	Нэмэгдэл	6,679,684.74	14,500,048.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	834,960.50	3,349,174.41
210201	Тэтгэврийн даатгал	834,960.50	3,349,174.41
2104	Хангамж, бараа материалын зардал	1,898,500.00	37,916,000.00
210401	Бичиг хэрэг	1,898,500.00	2,716,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	200,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	35,000,000.00
2105	Нормативт зардал	60,797,550.00	8,985,600.00
210502	Хоол, хүнс	60,797,550.00	8,985,600.00
2107	Томилолт, зочны зардал	15,341,850.00	14,198,400.00
210702	Дотоод албан томилолт	15,341,850.00	14,198,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	42,383,350.00	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	22,383,350.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	20,000,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	191,008,590.00	451,558,265.46
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	74,062,500.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	116,946,090.00	451,558,265.46
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	34,803,304.76	48,229,843.43
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	34,803,304.76	48,229,843.43
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	353,747,790.00	591,091,381.30
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	353,747,790.00	591,091,381.30
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	281,747,790.00	391,489,861.30
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	178,801,520.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	72,000,000.00	20,800,000.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Ц.Батдорж танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад анхаарах, бараа материал дансанд тавих хяналтыг сайжруулах, дотоод хяналтын тогтолцоог сайжруулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2020 оны 12 дугаар сарын 18-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Үндэсний аудитын газрын захиалгаар “Өлзийт экаунт аудит” ХХК-ийн аудитын баг хариуцаж хэрэгжүүлэв.

Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төрийн аудитын байгууллагад 2020 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 17 дугаар бүхий албан бичгээр хүргүүлэв.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Үнэлгээ гэрчилгээжүүлэлт

- Албан болон албан бус сургалт, амьдрах орчноос чадамж, мэргэжил эзэмшсэн төгсөгч, иргэний мэргэшлийн түвшинг үнэлж баталгаажуулах, гэрчилгээжүүлэх
- Мэргэжлийн боловсрол, сургалтын чанарт хөндлөнгийн үнэлгээ хийх, Сургалтын байгууллагын чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнийг боловсруулах, агуулгад дүгнэлт гаргах, зөвлөмж гаргах

Сургалтын судалгаа инноваци

- Мэргэшсэн үнэлээч бэлтгэх, салбарын хүний нөөцийг чадавхийг бэхжүүлэх, Техник мэргэжил боловсролын сургалтаар болон хөдөлмөрийн зах зээлд эрэлттэй, шинэ ажил, мэргэжлийн судалгаа эрхлэх, Салбарын үйл ажиллагаанд гарч буй шинэ санаа, бүтээл, брендийг дэмжиж олон нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэх

Сургалтын хэрэглэгдэхүүн мэдээллийн сан

- Мультмедиа сургалтын хэрэглэгдэхүүнийг боловсруулах, түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулах, чадамжид суурилсан сургалтын стандарт, хөтөлбөр, хэрэглэгдэхүүн, инновацийн мэдээллийн сан бүрдүүлэх, Үнэлгээ, гэрчилгээжүүлэлт баримт бичгийн мэдээллийн сан бүрдүүлж, лавлагаа хийх, Үнэлгээний тестийн сан бүрдүүлэх, Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын бүртгэл, инновацийг хөтлөж мэдээллийн санд байршуулах, Цахим хуудас хөгжүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Татварын ерөнхий хууль
- Хувь хүний орлогын албан татварын хуульд татварын хөнгөлөлт, чөлөөлөлт

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

ХНХЯ-ны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар 2020 онд Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй.

Тус төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “их” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд 2019 оны санхүүгийн тайлангийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 614,912.3 мянган төгрөгөөс тооцон 6,149.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж баталгаажуулсан.

Гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардал 1,468,567.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар тооцон 14,685.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж баталгаажууллаа.

3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 760,681.0 мянган төгрөгөөр буюу 68.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, урьдчилж төлсөн тооцоо, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

				/мянган төгрөг/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	
Б	1	2	3=2-1	
Мөнгөн хөрөнгө				
Авлага	34,803.3	47,241.5	12,438.2	
Урьдчилгаа	508.6	328,299.6	327,791.0	
Бараа материал	24,122.7	60,069.3	35,946.6	
Үндсэн хөрөнгө	1,589,987.8	1,972,492.9	382,505.1	
Нийт хөрөнгө	1,649,422.4	2,408,103.4	758,681.0	
Өр төлбөр	10,384.5	18,101.5	7,717.0	
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,639,037.9	2,390,001.9	750,964.0	
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,649,422.4	2,408,103.4	758,681.0	

Нэмэлт санхүүжилтээр ГОУХАН-ийн төслөөс олгогдсон санхүүжилтийн зарцуулагдаагүй 47,241.5 мянган төгрөгийн үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлж авлага үүсгэсэн дүнгээр авлагын үлдэгдэлтэй гарсан байна.

ХНХЯ-аас салбарын сургалт удирдлагын нэгдсэн мэдээллийн системийн эхний шатны хөгжүүлэлтийн төлбөр 220,000.0 мянган төгрөг, ГОУХАН-ийн нэмэлт санхүүжилтээр коронавирусээс шалтгаалан үүссэн сорилтуудыг давах, цахим сургалтын боломж, чадавхыг нэмэгдүүлэх, багш арга зүйчдийг чадавхжуулах, цахим сургалтанд шаардагдах тоног төхөөрөмжийг сайжруулах ажлын хүрээнд тайлант оны эцэст шилжүүлсэн 108,229.6 мянган төгрөг, нийт 328,199.6 мянган төгрөгөөр урьдчилж төлсөн тооцоо дансны үлдэгдэл өссөн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 60,069.3 мянган төгрөг болж 35,946.6 мянган төгрөгөөр өссөн нь Монгол-Солонгосын политехникийн коллеж, Дундговь аймгийн МСҮТ, Азийн хөгжлийн банкны Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх GS26 төсөл зэрэг байгууллагуудаас Сонгинохайрхан дүүрэгт байрлах шалгалтын байрны засвар, үйлчилгээ, тохижилтын ажлын бараа материал үнэ төлбөргүйгээр хүлээн авснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,972,492.9 мянган төгрөг болж 382,505.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд Монгол-Солонгосын политехникийн коллеж, Дундговь аймгийн МСҮТ, ХНХЯ, Азийн хөгжлийн банкны Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх GS26, GS28 төсөл зэрэг байгууллагуудаас үнэ төлбөргүй хөрөнгө хүлээн авснаас шалтгаалжээ.

Тайлант онд Axplorer санхүүгийн программыг 1,155.0 мянган төгрөгөөр худалдан авсан, 1,852.5 мянган төгрөгийн 2 жилийн хугацаатай вирусны программыг хүлээн авснаас биет бус хөрөнгө өссөн.

Өр төлбөр дансны үлдэгдэл 18,101.5 мянган төгрөг болж өссөн байна. Энэ нь оны эхний үлдэгдлээс 4,500.0 төгрөгийг барагдуулсан ба үлдэгдэл 5,250.1 мянган төгрөгийг төлөх төсвийг буцаан татсанаас, оны эцэст хүн амын орлогын албан татварын өр 3,510.2 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн өр 6,160.0 мянган төгрөгийг төлөөгүйгээс, ажилтан албан хаагчийн цалин хөлсийг дутуу тооцон олгосон 2,398.2 мянган төгрөг, нэр данс зөрүүтэй гүйлгээ буцаж орж ирснээс 783.0 мянган төгрөгийн өр тус тус үүссэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,390,001.9 мянган төгрөг болж 750,964.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүн эерэг үзүүлэлттэй гарснаас шалтгаалжээ.

2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлого өмнөх оноос 2,219,531.9 мянган төгрөг болж 169.6 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого, өөрийн үйл ажиллагааны орлого, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого байна. Энэ нь ХНХЯ-ны сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/326 тоот тушаалд “Мэргэжил боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвийн бүтэц, орон тоо, дүрмийг шинэчлэн батлах” тушаалд орон нутагт байрлах арга зүйн төвүүдийг тус төвд нэгтгэж, холбогдох зардлыг санхүүжүүлэх орлогыг хамааруулан төсвийг баталснаас шалтгаалжээ.

Нийт зардал өмнөх оноос 853,655.2 мянган төгрөгөөр буюу 138.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь дээр дурдсанчлан орон нутагт байрлах арга зүйн төвүүдийг тус төвд нэгтгэсэнтэй зардлууд нэмэгджээ.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 938,594.8 мянган төгрөгөөр тооцон нийт зарлагыг санхүүжүүлэхээр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 938,594.8 мянган төгрөгийн төсөв баталснаас 743,132.8 мянган төгрөгийг улсын төсвөөс 195,462.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 743,132.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 128,733.5 мянган төгрөг, нийт 871,866.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 868,188.3 мянган төгрөгийг зарцуулж үлдэгдэл 3,678.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 195,492.0 мянган төгрөг бүрдүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 128,733.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 65.8 хувиар биелүүлсэн байна. Энэ нь Ковид-19 цар тахлаас шалтгаалан сургалтын үйл ажиллагааг хязгаарласнаас шалтгаалжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 868,188.3 мянган төгрөг буюу 93 хувьтай байгаа нь орлогын төлөвлөгөө 66,728.4 мянган төгрөг буюу 34.2 хувиар тасарсантай холбоотой байна.

Урсгал зардлын гүйцэтгэл батлагдсан төлөвлөгөөтэй харьцуулахад үндсэн үйл ажиллагааны орлого тасарсантай холбоотой дараах зардлын гүйцэтгэл бүлгийн дүнгээр хэмнэлттэй харагдаж байна. Тухайлбал:

Үндсэн цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 37,804.3 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой зардал 10,758.3 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 3,422.5 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 12,263.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний зардал 804.9 мянган төгрөг, дотоод томилолтын зардал 5,345.4 мянган төгрөгөөр тус тус дутуу гүйцэтгэлтэй гарсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Гадаадын төсөл хөтөлбөрөөс 391,489.9 мянган төгрөгийн, дээд шатны төсвийн захирагчаас 178,801.5 мянган төгрөгийн, Монгол Улсын далайн захиргаа болон БНД-ийн Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих санд үзүүлсэн зөвлөх үйлчилгээний орлого 20,800.0 мянган төгрөгийн нийт 591,091.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд 26,854.1 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 3,349.2 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 37,916.0 мянган төгрөг, нормативт зардалд 8,985.6 мянган төгрөг, дотоод томилолтын зардалд 14,198.4 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 451,558.3 мянган төгрөг, нийт 591,091.4 мянган төгрөгийг зарцуулж үлдэгдэл 48,229.8 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс 120 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээлэл хугацаа болоогүй, 27 мэдээллийг хугацаа хоцроож байршуулжээ.

Шилэн дансанд байршуулсан мэдээллийг ерөнхий журналын орлого, зарлагын гүйлгээтэй тулгаж үзэхэд зөрүүтэй мэдээлэл илрээгүй бөгөөд хуулиар шаардсан бүх мэдээллийг байршуулж, тушаал шийдвэрүүдийг иж бүрэн оруулж ажилласан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 5,163.1 мянган төгрөгийн төлбөрийн 2 акт, 1 албан шаардлага биелэлт 100%, 7,118.1 мянган төгрөгийн 2 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Гүйцэтгэлийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Акт	2	5,163.1	2	5,163.1	-	-	100.0
Албан шаардлага	1		1		-	-	100.0
Зөвлөмж	2	7,118.1			2	7,118.1	0
Нийт дүн	5	12,281.2	3	5,163.1	2	7,118.1	

/мянган.төг/

Хэрэгжүүлээгүй шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан, нийгмийн даатгал, татварын тайлангийн үлдэгдлийг үнэн зөв илэрхийлээгүй 7,118.1 мянган төгрөгийн 2 зөвлөмж нь тайлант хугацаанд давтагдаж гарсан тул албан шаардлага хүргүүлсэн.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 346,543.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 46,724.1 мянган төгрөгийн алдааг залруулж, 54,837.3 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 244,981.9 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Жилийн эцсийн үндсэн хөрөнгийн тооллогын бүртгэлд 22,282.5 мянган төгрөгийн компьютер, түүний дагалдах хэрэгслийг тооллогын бүртгэлд нэгтгэж оруулаагүйг тооллогод хамруулан залруулсан.
2. Тайлант онд үнэ төлбөргүй хүлээн авсан 24,441.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, бараа материал, биет бус хөрөнгийг хөрөнгийн дансанд бүртгээгүйг санхүүгийн тайланд тусган залруулав.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 54,837.3 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчилд албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

1. Төгсөгчдийн ур, чадварын үнэлгээ хийхэд шаардлагатай 38,050.0 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авахдаа шууд худалдан авалт хийсэн. Энэ нь

ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д “харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар”, мөн хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.4-т “худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах, Засгийн газрын 2013 оны “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 68 дугаар тогтоолын хавсралтын 2 дахь заалттай нийцээгүй, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа материалын худалдан авалтыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу худалдан аваагүй алдаа, зөрчилд албан шаардлага хүргүүлэх.

2. Цахим баримтын ebarimt.mn системийн 291,165.1 мянган төгрөгийн и- баримтыг 5,000.0 мянган төгрөгөөс дээш үнийн дүнтэй мөнгөн зарлагын баримттай тулган үзэхэд 12,656.7 мянган төгрөгийн худалдан авалтын и-баримт цахим системд бүртгэлгүй. Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д “татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.” гэсэн заалтыг зөрчиж байна

Шийдвэрлэсэн нь: И-баримтын бүрдэл хангаагүй ажил гүйлгээ гаргасан зөрчилд албан шаардлага хүргүүлэх.

3. Санхүүгийн байдлын тайлангаарх нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөр 1,635.7 мянган төгрөгөөр дутуу, хувь хүний орлогын албан татварын тайлангийн өр төлбөр татварын тайлангаарх дүнгээс 2,494.9 мянган төгрөгөөр илүү нийт 4,130.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д зааснаар “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, УСНББОУС-1 стандартын 29-ийн Б-д “Байгууллага бүх нөхцөлд УСНББОУС-д нийцүүлэн үнэн зөв толилуулж хамааралтай, найдвартай, зэрэгцүүлэхүйц ойлгомжтой мэдээллээр толилуулах үүрэгтэй” гэж заалтуудтай нийцээгүй, иж бүрэн байх, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх оны аудитаар илэрсэн татвар, нийгмийн даатгалын тайланг зөв илэрхийлээгүй зөрчилд өгсөн зөвлөмж хэрэгжээгүй, энэ тайлант хугацаанд давтагдсан тул албан шаардлага хүргүүлэх.

4. Шилэн дансны цахим хуудсанд хуулийн дагуу байршуулах 27 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 244,981.9 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Тус төв нь Ковид-19 цар тахалтай холбоотой сургалтыг цахим хэлбэрт шилжүүлэх, сургалтын чадавх нэмэгдүүлэх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэхээр нийт 328,299.6 мянган төгрөгийн төлбөр хийгдэж, бүрэн дуусаагүй хөгжүүлэлтийн явцад байгааг нь анхаарал татахуйц тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

4.1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

4.1.1 Илрүүлэлт:

ХНХЯ-ны харьяа 3 байгууллагаас шилжин ирсэн 43 нэр төрлийн нийт 238,012.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нь үлдэх өртөггүй ирснийг үнэ шинэчлэн тогтоогоогүй нь УСНББОУС17-ийн 44-д “хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсний дараа, бодит үнэ цэнийг нь найдвартай хэмжиж чадах үндсэн хөрөнгийн зүйлийг түүний дахин үнэлсэн дүнгээр бүртгэж тусгана” гэж заасныг, харин ашиглах боломжгүй хөрөнгийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн өмчийн эд хөрөнгийг акталж, данснаас хасах журам”-ын 6 дугаар зүйлийн заалттай тус тус нийцэхгүй байна.

4.1.2 Эрсдэл:

Үнэлгээ ба хэмжилт батламж мэдэгдэл хангагдахгүй байх, үндсэн хөрөнгө бодит үнэ цэнээр илэрхийлэгдэхгүй байх эрсдэлүүд үүсч байна.

4.1.3 Өгсөн зөвлөмж:

Үлдэх өртөггүй шилжин ирсэн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоох, ашиглах боломжгүй хөрөнгийг холбогдох байгууллагад хүсэлт хүргүүлж данс бүртгэлээс хасах.

4.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, үлдэх өртөггүй хөрөнгийг зохих журмын дагуу шийдвэрлүүлж ажиллана.

4.2 Дотоод хяналттай холбоотой асуудал

4.2.1 Илрүүлэлт:

Санхүүгийн ажилтнуудын ажил үүргийн хуваарийг хянагдахуйц үр нөлөөтэй зохион байгуулаагүй, нярвын орон тоо байхгүйгээс жолооч хавсран гүйцэтгэдэг, нягтлан бодогч захиалагчийг төлөөлөн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан хөрөнгийн зарцуулалтыг хариуцан хийж байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-т “аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.9-д “дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрснөөр үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсвийн хүрээнд шинэчлэн тогтоох” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

4.2.2 Эрсдэл:

Байгууллагын дотоод хяналтын тогтолцоо сул, санхүүгийн ажилтнуудын ажил үүргийн хуваарь тодорхойгүй байх.

4.2.3 Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн ажилтнуудын ажиллах ажил үүргийн хуваарь, орон тоог шинэчлэн дотоод хяналтын тогтолцоог хангахуйц бүтэц зохион байгуулахыг зөвлөж байна.

4.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Байгууллагын санхүүгийн ажилтны ажил үүргийн хуваарь, орон тоог шинэчлэн хяналтын тогтолцоо бүрдүүлэн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

4.3 Бараа материалын данстай холбоотой асуудал.

4.3.1 Илрүүлэлт:

Тайлант онд худалдан авсан 1,232.0 мянган төгрөгийн чадамжийн гэрчилгээ, сургалтын сертификат хэвлэдэг үнэт цаас, 5,737.3 мянган төгрөгийн шатахуун нийт 6,969.3 мянган төгрөгийн худалдан авалт хийж бараа материалын дансанд орлого авч зарцуулалтыг хяналгүй шууд зардалд бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т "аж ахуйн нэгж байгууллагын удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичилт хийж бүрдүүлнэ", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 390 тоот тушаалын нэгдүгээр хавсралт "Автомашин 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм"-ыг, УСНББОУС-1 стандартын 29-ийн Б-д "Байгууллага бүх нөхцөлд УСНББОУС-д нийцүүлэн үнэн зөв толилуулж хамааралтай, найдвартай, зэрэгцүүлэхүйц ойлгомжтой мэдээллээр толилуулах үүрэгтэй" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

4.3.2 Эрсдэл:

Худалдан авалт хийж байгаа хөрөнгө хяналтгүй зарцуулагдах, толилуулга ба тодруулга, иж бүрэн байх батламж мэдэгдэл хангагдахгүй байх эрсдэлүүд үүссэн байна.

4.3.3 Өгсөн зөвлөмж:

Худалдан авалт хийхдээ бараа материалыг орлогод авч зарцуулалтыг хянаж, данс бүртгэлд тусгахыг зөвлөж байна.

4.3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн бараа материалын тайлан бэлтгэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2020			САГ-2021/113/СТА-
Шалгагдсан байгууллагын нэр:	Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төв		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Санхүүгийн ажилтнуудын ажил үүргийн хуваарь хянагдахуйцаар зохион байгуулагдаагүй, нярвын орон тоо байхгүй жолооч хавсран гүйцэтгэдэг, нягтлан бодогч захиалагчийг төлөөлөн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулсан байна.		Зөвлөмж өгөх	Дарга, Ерөнхий нягтлан бодогч	Ц.Батдорж, У.Энххүү
2	Төгсөгчдийн ур, чадварын үнэлгээ хийхэд шаардлагатай 38,050.0 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авахдаа шууд худалдан авалт хийсэн	38,050.0	Албан шаардлага өгөх	Дарга, Ерөнхий нягтлан бодогч	Ц.Батдорж, У.Энххүү
3	ebarimt.mn цахим баримтын системийн 291,165.1 мянган төгрөгийн и баримтыг 5,000.0 мянган төгрөгөөс дээш үнийн дүнтэй мөнгөн зарлагын баримттай тулган үзэхэд 12,656.7 мянган төгрөгийн и-баримт бүртгэгдээгүй	12,656.7	Албан шаардлага өгөх	Ерөнхий нягтлан бодогч	У.Энххүү
4	Мөнгөн хөрөнгийн 878,595.3 мянган төгрөгийн зарлагын журналын гүйлгээнээс ҮЦ ХХК -д шилжүүлсэн дүнг түүвэрлэн үнэт цаасны тооцоо бүртгэлийн тайлантай тулгаж горим гүйцэтгэхэд 1,232.0 мянган төгрөгийн үнэт цаасыг орлого авч зарцуулалтанд хяналт тавилгүй зардалд бүртгэсэн.	1,232.0	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч	У.Энххүү
5	Мөнгөн хөрөнгийн 878,595.3 мянган төгрөгийн зарлагын журналаас шатахуун худалдан авахаар шилжүүлсэн дүнг түүвэрлэн шатахууны тайлан, жолоочийн замын хуудастай тулган шалгах горим хэрэгжүүлэхэд 2020 онд шатахууныг бараа материалын орлогод авч зарцуулалтанд хяналт	5,737.3	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч	У.Энххүү

	тавьж бүртгээгүй 5,737.3 мянган төгрөгийн зөрчил илэрсэн.				
6	Санхүүгийн байдлын тайлангаарх нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөр 1,635.7 мянган төгрөгөөр дутуу, хувь хүний орлогын албан тайлангийн өглөг татварын тайлангаарх дүнгээс 2,494.9 мянган төгрөгөөр илүү нийт 4,130.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.	4,130.6	Албан шаардлага өгөх	Ерөнхий нягтлан бодогч	У.Энххүү
7	ХНХЯамны харьяа 3 байгууллагаас шилжин ирсэн 43 нэр төрлийн нийт 238,012.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нь үлдэх өртөггүй.	238,012.6	Зөвлөмж өгөх	Дарга, Ерөнхий нягтлан бодогч	Ц.Батдорж, У.Энххүү
8	Шилэн дансны цахим хуудсанд хуулийн дагуу байршуулах 27 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан.		Албан шаардлага өгөх	Дарга, Ерөнхий нягтлан бодогч	Ц.Батдорж, У.Энххүү
ДҮН		299,819.2			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25 № 179/АД160062
СРГ-2001/113/СТА-Пчз
Зөрчил арилгуулах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл арга зүйн төвийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Шилэн дансны цахим хуудсанд хуулийн дагуу байршуулах 149 мэдээллээс 27 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж, мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвийн дарга Ц.Батдорж, Ерөнхий нягтлан бодогч У.Энххүү нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

Б.ЭНХЖИН

Т.ОТГОНЦЭЦЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25 № 180/АД160062
СРГ- 2021/113/СТА-ТЦЗ
Зөрчил арилгуулах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл арга зүйн төвийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл арга зүйн төв нь бараа материалыг худалдан авахдаа 38,050.0 мянган төгрөгийн шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д "харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар", 8.4-т "Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно", мөн хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.4-т "худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;" Засгийн газрын 2013 оны 68 дугаар тушаалаар батлагдсан "Босго үнэ шинэчлэн батлах тухай" журмын хавсралтын 2-д "Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгадагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн

ШААРДАХ нь:

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, зөрчлийг арилган биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газар ирүүлэх
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвийн дарга Ц.Батдорж, Ерөнхий нягтлан бодогч У.Энххүү нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.ЭНХЖИН
ОТГОНЦЭЦЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 181/A0160062

Улаанбаатар хот

СБТ- 0021/113/СТА-ПЦЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл арга зүйн төвийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. ebarimt.mn цахим баримтын системийн 291,165.1 мянган төгрөгийн и-баримтыг 5,000.0 мянган төгрөгөөс дээш үнийн дүнтэй мөнгөн зарлагын баримттай тулган үзэхэд 12,656.7 мянган төгрөгийн худалдан авалтын и-баримт цахим системд бүртгэлгүй байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ." гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. И-баримтын бүрдэл хангаагүй ажил гүйлгээ гаргасан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газар ирүүлэх
2. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг Үндэсний аудитын газарт 2021 оны 03 дугаар сарын 10-ны дотор албан ёсоор ирүүлэхийг Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвийн дарга Ц.Батдорж, Ерөнхий нягтлан бодогч У.Энххүү нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

Б.ЭНХЖИН

ОТГОНЦЭЦЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 182/АД160062

Улаанбаатар хот

СЯТ-2021/113/СТА-ПЧЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл арга зүйн төвийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Санхүүгийн байдлын тайлангаарх нийгмийн даатгалын шимтгэлийг 1,635.7 мянган төгрөгөөр дутуу, Татварын тайлангаарх хувь хүний орлогын албан татварын өр төлбөрийг 2,494.9 мянган төгрөгөөр илүү тооцож нийт 4,130.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д зааснаар “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, УСНББОУС-1 стандартын 29-ийн Б-д “Байгууллага бүх нөхцөлд УСНББОУС-д нийцүүлэн үнэн зөв толилуулж, хамааралтай, найдвартай, зэрэгцүүлэхүйц ойлгомжтой мэдээллээр толилуулах үүрэгтэй”, мөн санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх”, “үнэн зөв байх” батламж мэдэгдлүүдтэй тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгадагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх оны аудитаар илэрсэн татвар, нийгмийн даатгалын тайланг зөв илэрхийлээгүй зөрчилд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, төсвийг зохистой удирдаж, үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөн зарцуулж биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газар ирүүлэх
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төвийн дарга Ц.Батдорж, Ерөнхий нягтлан бодогч У.Энххүү нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.ЭНХЖИН
Т.ОТГОНЦЭЦЭГ

[illegible]

[illegible]

[illegible]